



ЗАВХАН АЙМГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС



АЙМГИЙН АЖ ҮЙЛДВЭР, БАРИЛГА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАРЫН ТАНИЛЦУУЛГА



2018 он

АГУУЛГА:

1. Судалгааны агуулга, зорилт
2. Аж үйлдвэрийн салбарын үүсэл хөгжил
3. Аж үйлдвэрийн салбарын өнөөгийн байдал
4. Үйлдвэрлэл салбараар
5. Үйлдвэрлэл улсын түвшний харьцуулалт
6. Аймгийн нийт үйлдвэрлэл баруун бүсийн түвшинд харьцуулалт
7. Нийт үйлдвэрлэл биет хэмжээгээр харьцуулалт
8. Барилгын салбарын танилцуулга
9. Үйлчилгээний салбар
10. Дүгнэлт
11. Ашигласан материал

СУДАЛГААНЫ ЗОРИЛГО

Аймгийн эдийн засаг, дэд бүтцийн үндсэн үзүүлэлтүүдээр нэгдсэн танилцуулга бэлдэж тэдгээр үзүүлэлтүүдэд гарсан өөрчлөлт, цаашдын чиг хандлагыг тодорхойлж орон нутгийн удирдлагыг дэлгэрэнгүй мэдээллээр хангахад чиглэнэ.

Нэг. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАР

А. Аймгийн аж үйлдвэрийн салбарын үүсэл хөгжил

Аж үйлдвэрийн салбарын үүсэл хөгжил.

Аймгийн аж үйлдвэрийн салбар нь анх 1925 онд *Архи худалдаалах сангийн хороо* нэртэйгээр байгуулагдсан хүнсний үйлдвэрээр манай аймгийн аж үйлдвэрийн салбарын суурь тавигдсан билээ. Завхан аймагт аж үйлдвэрийн улсын чанартай томоохон аж ахуйн газар нилээд хожим хүртэл бараг байгуулагдаагүй ажээ. 1937 онд тус аймагт Дийвийжанцан даргатай гар үйлдвэрийн төлөөлөгчийн газар байгуулагдсан нь гар үйлдвэрийн хоршооллын артелиуд байгуулагдаж эхэлжээ. 1937 оны эцсээр аймгийн төв Жавхлант, Алдархаан зэрэг газар гар үйлдвэрийн артель хэд хэд байгуулагдаж 150 гаруй гишүүд, гар урчууд нэгдэж 17889 төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн байна. Артелиуд цаашид өргөжиж, хувь хөрөнгө, хөдөлмөрийн багаж зэргээ сайн дурын үндсэн дээр нийгэмчлэн хөдөлмөрөө хорших замаар зохион байгуулагдаж үйлдвэрийн хоршооллын байгууллагын хэлбэрт орон хөгжих болжээ.


1938 онд хүн амын өргөн хэрэглээний хувцас үйлдвэрлэдэг гар үйлдвэрлэлийн хоршоодын холбоо, 1945 онд хэвлэлийн үйлдвэр, 1963 онд Тосонцэнгэлийн мод боловсруулах комбинат, 1966 онд авто тээврийн 20-р баазын харъяанд байсан дизель станц бие даасан эрчим хүчний үйлдвэр болсон ба мөн онд ойг нөхөн сэргээх, хамгаалах үүрэг бүхий ойн аж ахуй ажиллажээ. 1968 онд жилдээ 150 автомашин, 120 хөдөлгүүрт их засвар хийх хүчин чадалтай авто засварын газар, 1972 онд барилгын материалын үйлдвэр болон жилдээ 10000 тн багсармал тэжээлийн үйлдвэр Тэс сумд ашиглалтанд орж, 1983 онд жилдээ 1500 тн малын мах үйлдвэрийн аргаар боловсруулах хүчин чадалтай мах боловсруулах үйлдвэр, 1984 онд жилдээ 75мян,г,кал дулаан үйлдвэрлэх хүчин чадалтай төвлөрсөн уурын зуух, жилдээ 500тн угаалгын нунтаг үйлдвэрлэх хүчин чадалтай угаалгын нунтгийн үйлдвэр Дөрвөлжин сумын нутаг Хомын талд ашиглалтанд орж байжээ. Тухайн үед аймгийн эрчим хүчний нэгдсэн үйлдвэр, сумдын дизель станц, халаалтын зуухнуудыг нэгтгэн жилдээ 16.6 сая. квт/цаг


цахилгаан, 75 мян.г.кал дулаан үйлдвэрлэж байв.1983-1986 онд Тосонцэнгэлийн мод боловсруулах комбинатын өргөтгөл, шинэчлэлт хийгдэж, тус комбинатын дулаан үйлдвэрлэл жилдээ 32 мян.г.кал дулаан үйлдвэрлэж байв. 1985 онд барилгын материалын үйлдвэрийн, 1986 онд хүнсний үйлдвэрийн өргөтгөл, шинэчлэлт хийгдэж хэвлэх үйлдвэрийн барилга баригдаж ашиглалтанд орсон байна.Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн системээс зах зээлийн эдийн засгийн системд шилжсэнээр тухайн үеийн үйлдвэрлэл зогсонги байдалтай байсан боловч 90 оны дунд үеэс орчин үеийн техник, технонологи нэвтэрж үйлдвэрийн салбар сэргэж байна. Цахилгаан үйлдвэрлэлийн хувьд 24 сум төвлөрсөн системд холбогдож Тайшир, Идэр, Богд, Хүнгүй, Галуутайн голын усан станцууд баригдан ашиглалтанд орсоноор жижиг дунд үйлдвэрлэл хөгжих таатай нөхцөл бүрдэж, жилд дунджаар 1500 тн ноос угааж, 20000 кв.м эсгий үйлдвэрлэх үйлдвэр, мах боловсруулах 2 үйлдвэр, гурилын үйлдвэрүүд шинээр ашиглалтанд орсоноор 2015 оны аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл оны үнээр 10 тэрбум 870,4 сая төгрөг болж 2010 оноос 4.5 хувиар буюу 460,6 сая төгрөгөөр өсч, өнгөрсөн оноос 6.9 хувиар буюу 758 сая төгрөгөөр буурсан нь цахилгаан үйлдвэрлэл 1016,8 сая төгрөгөөр буурсан нь нөлөөлжээ.

В. Аймгийн үйлдвэрлэл

Аймгийн 2017 оны аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл оны үнээр 13тэрбум 382.2 сая төгрөг болж, өнгөрсөн оноос 20.2 хувиар буюу 2 тэрбум 701.9 сая төгрөгөөр өссөн нийт үйлдвэрлэлээс ААНэгжийн үйлдвэрлэл нь 7тэрбум 266.6 сая төгрөг, иргэдийн үйлдвэрлэл нь 6 тэрбум 115.6 сая төгрөг болсон байна.

Тайлант хугацаанд улсын мэдээнд орсоноор 123.0 тэрбум алт , 2.3 тэрбум мөнгө олборлолт хийсэн байна.






Үйлдвэрлэлд цахилгаан, дулаан, усан хангамжийн үйлдвэрлэл 43.1 хувийг, хүнсний үйлдвэрлэл 32.8 хувь, хувцас үйлдвэрлэл 12.4 хувь, модон эдлэл үйлдвэрлэл 8.7 хувь, эсгий эдлэл үйлдвэрлэл 0.6 хувь, өлөн гэдэс үйлдвэрлэл 0.2 хувь, барилгын ханын материал үйлдвэрлэл 1.0 хувь, вакум цонх үйлдвэрлэл 0.5 хувь, бусад үйлдвэрлэл 0.7 хувийг тус тус эзэлж байна.

Мэдээнд хамрагдсан аж ахуйн нэгжид нийт 715 ажиллагсад ажиллан нийт үйлдвэрлэлд аж ахуйн нэгжийн үйлдвэрлэл 54.3 хувийг иргэний үйлдвэрлэл 45.7 хувийг эзлэж байна.

Боловсруулах аж үйлдвэрийн салбарын бүтцийг авч үзвэл:


	Дүнд эзлэх хувь		Өөрчлөлт/өсөлт+ бууралт-/
	2016	2017	
Хүнсний бүтээгдэхүүн, үйлдвэрлэл /өлөн гэдэс боловсруулалт ороод/	22,0	33	11
Хувцас үйлдвэрлэл	16,5	12.4	-4.1
Мод модон эдлэл үйлдвэрлэл	8,6	8.7	0.1
Ханын материал үйлдвэрлэл	1,0	1.5	0.5
Бусад үйлдвэрлэл /эсгий, эсгий эдлэл ороод /	1,4	1.3	-0.1

Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл /бүтэц, хувиар/



Хүнсний салбарын нийт үйлдвэрлэлт 4395,5 болсон нь өмнөх оны мөн үетэй харьцуулхад 2035.1 сая төгрөгөөр нэмэгдсэн нь шинээр хувиараа хөдөлмөр эрхлэгчид, бүтээгдэхүүн үйлдвэрлэл нэмэгдсэнтэй холбоотой байна.

Баруун бүсийн хүнсний үйлдвэрлэл нийт үйлдвэрлэлд эзлэх / хувиар /





Баруун бүсэд хүнсний үйлдвэрлэл нь Завхан 32.8%, Говь-алтай 9%, Баян-өлгий 3%, Увс 30%, Ховд 2.6%, эзэлж байна.

Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийн 2007 оноос хойшхи өсөлт, бууралтыг диаграммаар үзүүлбэл:



Сүүлийн 10 жилээр нийт үйлдвэрлэлтийг авч үзэхэд жил тутам өссөн байдалтай байна. Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт 2007-2011 он хүртэлх жигд өсөлттэй байгаа бөгөөд 2012 оноос бууралттай харагдаж байгаа нь төвлөрсөн эрчим хүчний системд холбогдож, орон нутагт цахилгаан үйлдвэрлэж байсан өндөр өртөгтэй дизель станцийн үйлдвэрлэл багассанаар улсаас авч байсан татаац зардлын хэмжээ буурч байгаагаас бууралт харагдаж байгаа хэдий ч нь орон нутаг дахь бусад жижиг дунд үйлдвэрлэлийн цар хүрээ, дэд бүтцийн өсөлт нэмэгдэж байгаа нь нийт үйлдвэрлэлийн өсөлтөнд эерэгээр нөлөөлөх хандлага гарч байна.





Аймгийн аж үйлдвэрийн үндсэн үзүүлэлтүүд

Он	Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт, оны үнэ, сая.төг	Бүтээгдэхүүн борлуулалт, оны үнэ, сая.төг	Ажиллагсдын тоо	Хөдөлмөрийн бүтээмж, сая.төг	Нэг өдрийн үйлдвэрлэлт, сая.төг	Нэг хүнд ноогдох аж үйлдвэрийн бүтээгдэхүүн, мян.төг
2007	6415.2	6390.4	780	8.2	25.7	80.7
2008	7682.5	7670.4	724	10.6	30.7	100.3
2009	8689.6	8653.2	735	11.8	34.8	116
2010	10189.7	10181.8	793	12.8	40.8	141.8
2011	11594.6	11546.2	868	13.3	46	163.8
2012	11648.5	11646.4	870	13.4	46.2	167.1
2013	10723.8	10642.7	902	11.9	42.6	153.6
2014	11628.4	11628.4	968	12	44.6	167.1
2015	10870.4	10762.5	1024	10.5	42.5	155.1
2016	10680.3	10680.3	1026	10.4	40.5	150.7
2017	13382.2	13382.2	1033	12.9	50.5	185.6

Нэг хүнд ногдох аж үйлдвэрийн бүтээгдэхүүний хэмжээ 2007 онд 80.7 мянган төгрөг байсан бол 2017 оны байдлаар 185.6 мян төгрөг буюу 2.3 дахин өссөн байгаа нь жил бүр тогтмол өсөлттэй байсныг харуулж байна. Аймгийн аж үйлдвэрийн салбарт 1033 ажиллагсад ажиллаж нэг ажиллагчийн хөдөлмөрийн бүтээмж 12.9 сая төгрөг, жилд дунджаар 50.5 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж байна. Аж үйлдвэрийн салбарт ажиллагсадын тоо аймгийн нийт ажиллагсдын 3.1 хувийг эзэлж байна.

Завхан аймгийн аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийг баруун бүсийн аймгуудын бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийн хэмжээтэй харьцуулан судаллаа.

Баруун бүсийн аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэлт

Аймаг	/сая,төг/										
	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017
Завхан	6415.2	7682.5	8689.6	10189.7	11665.4	11648.5	10723.8	11628.4	10870.4	10680.3	13382.2
Говь-Алтай	3478.1	6537.7	5578	11253.3	13870.9	12096.4	13938.4	10818.4	11735.4	13223.1	10880.1
Баян-өлгий	5204.9	8337	8024.5	8606.8	11284	11312.4	7445	12220.1	13921.6	11933.3	22763.7
Ховд	1696	2325.7	3852.1	4019.0	5710.2	4568.3	5533.6	5622.2	9468.2	9168.8	61498,3
Увс	3204.2	3989.1	5031.9	5784.8	12468.6	7661.6	8473.7	8955.6	13100	9435	13636.8
Бүсийн дүн	16794.2	24882.9	26144.2	30049.8	54999.1	47287.2	46114.5	49244.7	59095.6	54440.5	186572

2017 онд аймгийн аж үйлдвэрийн салбар баруун бүсийн нийт бүтээгдэхүүний 13.9 хувийг үйлдвэрлэсэн байна.

АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ГОЛ НЭР ТӨРЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛ, өссөн дүнгээр

Гол нэр төрлийн бүтээгдэхүүн	Хэмжих нэгж	2013	2014	2015	2016	2017	ҮҮНЭЭС	
							ААНэгж	иргэд
Цахилгаан дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамж								
Цахилгаан эрчим хүч	мян.квт.ц	12482.2	6021.4	5139.0	4949	4680.1	4680.1	
Дулааны эрчим хүч	мян.г.кал	190.8	241.5	241.2	287.7	313.8	313.8	
Боловсруулах аж үйлдвэр								
Савхин гутал	хос	1839.0	1892.0	2363.0	2174.0	950.0		950.0
Хүүхдийн гутал	хос	564.0	357.0	812.0	856.0	473.0		473.0
Монгол гутал	хос	1178.0	1183.0	1466.0	1571.0	1047.0	89.0	958.0
Монгол дээл/зөөлөн оёдол/	ширхэг	7613.0	12521.0	6965.0	11590.0	13197.0	1960.0	11237.0
Талх	тонн	749.8	459.8	350.6	324.4	449.8	20.6	429.2
Нарийн боов	тонн	888.3	626.9	448.5	384.5	511.4	23.6	487.8
Чихэр	тонн	3.7	11.1	3.9	2.3	8.2	8.2	
Архи, дарс	мян.л	53.0	39.4	46.1	40.0	45.7	45.7	
Ундаа ,Хийжүүлсэн ус	мян.л	15.9	16.2	187.4	401.5	266.9	266.9	
Хаим	тонн	0.3	1.8	2.4	4.8	6.8	6.8	
Ус борлуулалт	мян.куб.м	200.0	172.2	215.7	202.0	185.2	185.2	

Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл 2010 онтой харьцуулахад нийт үйлдвэрлэл 3.1 хувь буюу 3192.5 мянган төгрөгөөр өссөн байна. Эдгээр өсөлт, бууралтанд үйлдвэрийн нэгжийн үнийн өөрчлөлт, бүтээгдэхүүний биет хэмжээний өөрчлөлт суурь онтой харьцуулахад хэрхэн нөлөөлсөнийг Талх, нарийн боов, чихэрийн үйлдвэрлэлийг статистикийн индексийн шинжилгээний аргаар тооцож үзлээ:

Үйлдвэрлэсэн Талх, нарийн боов, чихэрийн нэгжийн үнийн өөрчлөлтийн нөлөөлөл:

$$I_p = \frac{\sum Q_1 P_1}{\sum Q_1 P_0} = \frac{2671.5}{1540.7} \approx 173.3 \text{ хувиар буюу } 1.7 \text{ дахин үйлдвэрийн үнэ өссөн нь}$$

үйлдвэрлэлтийг 1130.8 сая төгрөгөөр өсөхөд нөлөөлсөн байна.

2. Биет хэмжээний өөрчлөлтийн нөлөөлөл:

$$I_q = \frac{\sum Q_1 P_0}{\sum Q_0 P_0} = \frac{969.4}{500.4} \approx 193.7 \text{ хувиар буюу } 1.9 \text{ дахин өссөн нь үйлдвэрлэлийн биет хэмжээг}$$

469 мян.кг өсөхөд нөлөөлсөн байна.

Хоёр. Барилгын салбар

ИХ БАРИЛГА

2017 онд барилгын салбарын мэдээнд барилга угсралт, их засвар, бүтээн байгуулалтын ажилд аймгийн дүнгээр 104 тэр бум 971.2 сая төгрөгийн ажил гүйцэтгэснийг салбараар үзвэл:

Орон сууцны барилга 544.4 сая төгрөг, орон сууцны бус барилга 6 тэрбум 653.0 сая төгрөг, боловсрол соёлын салбарын бүтээн байгуулалтын 5 тэр бум 333.0 сая төгрөг, авто замын ажил 96 тэрбум 250.4 сая төгрөг, бусад 1 тэрбум 320.0 сая төгрөгийн барилга угсралт, их засварын ажлыг гүйцэтгэсэн байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад барилга угсралт, их засварын ажил 4.4 дахин өссөн байна.



БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖИЛ
ТӨРЛӨӨР /мян.төг/

Барилгын төрөл	2016	2017					2017 I-XII 2016I-XII %
	I-XII	I-III	IV-VI	VII-IX	X-XII	I-XII	
Нийт	23822.1	855.4	63775.8	35606.7	4733.3	104971.2	4.4²
Орон сууцны барилга	905.6	244.4			300.0	544.4	60.1
Орон сууцны бус барилга	12872.5	611.0	457.0	4250.0	1335.0	6653.0	51.7
Худалдаа, үйлчилгээний	171.6						0.0
Эмнэлэгийн							
Сургууль, соёлын	7407.5		457.0	4141.0	735.0	5333.0	72.0
Бусад	3713.3	611.0		109.0	600.0	1320.0	35.5
Инженерийн барилга, байгууламж	9790.4		62795.9	30764.2	2690.3	96250.4	9.8²
Эрчим хүчний	480.7						0.0
Авто зам	7540.4		62795.9	30764.2	2690.3	96250.4	12.7²
Их засварын ажил	1833.7		522.9	592.5	408.0	1523.4	83.1

*² дахин их

Дүгнэлт

Завхан аймгийн хэмжээнд аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийг сүүлийн 10 жилийн байдлаар авч үзэхэд жил бүр тогтмол өсөлттэй байгаа ба 2007 онд нийт үйлдвэрлэлт 6415.2 сая төгрөг байсан бол 2017 онд нийт үйлдвэрлэл 13382.2 сая төгрөгт хүрч үйлдвэрлэл 2.0 дахин буюу 6967 сая төгрөгөөр өссөн байна. Сүүлийн жилүүдэд үйлдвэрлэлийн хэмжээний тогтмол өсөлтөнд төрөөс явуулж буй жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих, дэд бүтцийг хөгжүүлэх бодлогын хүрээнд хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөр, санхүүгийн дэмжлэг зэрэг нь нөлөөлж байна.

Нийт үйлдвэрлэлд цахилгаан, дулаан, усан хангамжийн үйлдвэрлэл 43.1 хувийг, хүнсний үйлдвэрлэл 32.8 хувь, хувцас үйлдвэрлэл 12.4 хувь, модон эдлэл үйлдвэрлэл 8.7 хувь, эсгий эдлэл үйлдвэрлэл 0.6 хувь, өлөн гэдэс үйлдвэрлэл 0.2 хувь, барилгын ханын материал үйлдвэрлэл 1.0 хувь, вакуум цонх үйлдвэрлэл 0.5 хувь, бусад үйлдвэрлэл 0.7 хувийг тус тус эзэлж байна.

Мэдээнд хамрагдсан аж ахуйн нэгжид нийт 1033 ажиллагсад ажиллан, нийт үйлдвэрлэлд ААНэгжийн үйлдвэрлэл нь 7266.6 сая төгрөг, иргэдийн үйлдвэрлэл нь 6115.6 сая төгрөг болсон байна. Хүнсний салбарын үйлдвэрлэл болон Гутал, хувцас үйлдвэрлэл /оёдол/, модон эдлэлийн үйлдвэрлэл нь илүү өсөлттэй байгаа нь нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн өсөлтөнд эерэгээр нөлөөлж байна. Бусад салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хувьд жигд өсөлттэй байна.

Аймгийн аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлтүүдийг авч үзхэд нэг ажилтны хөдөлмөрийн бүтээмж, нэг өдрийн үйлдвэрлэлтийн хэмжээ, нэг хүнд ногдох үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний хэмжээ зэрэг жил бүр нийт үйлдвэрлэлийн хэмжээний өсөлтийг даган жигд өсөж байна.

Цаашид үйлдвэрлэлийн хэмжээ, зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийг улам хурдацтай нэмэгдүүлэх, хангахад жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих, санхүүгийн болон тоног төхөөрөмж бусад хөнгөлөлт, эх үүсвэрийг нэмэгдүүлэх зайлшгүй шаардлагатай байгаа бөгөөд түүнд нөлөөлөх гол хүчин зүйл болох замын асуудлыг цогц хэлбэрээр хурдацтай хөгжүүлэх нь чухал ач холбогдолтой байна.

Манай аймгийн хувьд зах зээлээс алслагдмал, дэд бүтэцийн хөгжил сул, хүн амын нягтаршил бага байдаг зэрэг нь жижиг дунд үйлдвэрлэлийн өсөлтөнд зарим талаар нөлөөлж байна.

Барилга угсралт, их засварын ажил нь орон сууцны барилга 544.4 сая төгрөг, орон сууцны бус барилга 6 тэрбум 653.0 сая төгрөг, боловсрол соёлын салбарын бүтээн байгуулалтын 5 тэр бум 333.0 сая төгрөг, авто замын ажил 96 тэрбум 250.4 сая төгрөг, бусад 1 тэрбум 320.0 сая төгрөгийн барилга угсралт, их засварын ажлыг гүйцэтгэсэн байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад барилга угсралт, их засварын ажил 4.4 дахин өссөн байна.

Энэ онд манай аймагт дараах объектууд ашиглатанд орсон байна.

Үүнд: 29 айлын орон сууцны барилга, АХКомпаний конторын барилга, Цэцэрлэг-Нөмрөг-Тосонцэнгэл чиглэлийн хайрган хучилттай авто зам арчлалт, Улиастай-Алтай чиглэлийн хайрган хучилттай авто замын арчлалт, Завхан аймгийн Хөгжимт жүжгийн театрын их засвар, Нэгдсэн эмнэлэгийн мэс заслын тасгийн их засвар, Улиастай-Сар хайрхан чиглэлийн зам арчлалт, Улиастай-Алтай чиглэлийн авто зам арчлалт,

Улиастай-Мөрөн чиглэлийн авто зам арчлалт, 40 айлын орон сууцны барилга, Спорт цогцолборын барилга /Завхан, Улиастай сум/, Аварх гал унтраах ангийн барилга /Завхан, Улиастай сум /, Улиастай сумын 3-р сургуулийн дэд өртөөний барилга, Олон цохиотын худаг, Алдархаан сумын сургуулийн засвар, Баянхайрхан сумын 160 хүүхдийн хичээлийн байр, Идэр сумын сургуулийн дотуур байрны их засвар, 640 хүүхдийн хичээлийн байр, Нөмрөг сумын ХААН банкны барилга, Тосонцэнгэл сумаас Улиастай чиглэлийн 114 км хатуу хучилттай авто замын ажил, Нөмрөг Баянтэс чиглэлийн хайрган хучилттай авто замын арчлалт, Тосонцэнгэл сумын 160 хүүхдийн хичээлийн байрны их засвар, Улаан дэнжийн худаг Цагаанбулгийн эх худаг Улаан үзүүрийн худаг, Төвийн худаг ,Сургуулийн худаг, Их хөндлөнгийн худаг Улаан сээрийн худаг ашиглалтанд орсон байна.

Ашигласан ном материал

1. Аймгийн нийгэм, эдийн засгийн 2007-2017 оны эмхэтгэл
2. Монгол улсын статистикийн 2007-2017 эмхэтгэлүүд
3. Албан ёсны болон захиргааны сар, улирал, жилийн эмхэтгэлүүд
4. Бусад эх сурвалж

Хянасан: Статистикийн хэлтсийн дарга Б.Цэгмид

Танилцуулга бичсэн: Статистикийн хэлтсийн

мэргэжилтэн Б.Энхмаа